



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛЭЭС

2018 оны 11 сарын 20 өдөр

Дугаар 28

Улаанбаатар хот


Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдааны 28 дугаар тэмдэглэлд:

LV.ХЭЛЭЛЦСЭН нь: Монгол бөхийн өргөөтэй холбоотой үүссэн зарим асуудлын тухай

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын зүгээс Монгол бөхийн өргөөнд “Бүрэн эрхт төлөөлөгч” томилох хууль, эрх зүйн зохицуулалт байхгүй тул Монгол Улсын Засгийн газар Монголын үндэсний бөхийн холбооны маргаантай асуудал хууль, хяналтын байгууллагаар эцэслэн шийдвэрлэгдэх хүртэлх хугацаанд Монгол бөхийн өргөөг төрийн мэдэлд авч, үйл ажиллагааг хэвийн явуулах зорилгоор үндэсний бөхийн барилдаанууд болон бусад урлаг соёлын арга хэмжээ зохион байгуулах шийдвэр гаргасан нөхцөлд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд төрийн өмчийн төлөөлөгч томилж болно.

2. Монгол бөхийн өргөөтэй холбоотой тодорхойгүй болон цаашид шийдвэр гаргахад шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлэх, Төрийн өмчийн хороо /хуучин нэрээр/ болон Монголын үндэсний бөхийн холбооноос гаргасан шийдвэрүүдийн хууль зүйн үндэслэлийг нягтлах, Бөхийн өргөөг төрийн өмчид бүртгэх асуудлаар санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яам, Барилга, хот байгуулалтын яам, Үндэсний аудитын газар, Санхүүгийн зохицуулах хороо, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын төлөөллийг оролцуулан байгуулах саналыг Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлэх нь зүйтэй гэж үзлээ.” гэжээ.



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР